

## МОНГОЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ АНУ НААШТАЙ ҮНЭЛЖ БАЙНА

("АНУ-Монголын бизнесийн зөвлөл" корпорацийн ивээл дор 1993 оны 6 дугаар сарын 16-нд Вашингтон хотноо хийгдсэн эрдэм шинжилгээний хурал дээр АНУ-ын төрийн департамент дахь Монгол, Хятадын хэргийг харуусан түшмэл Роберт Перитогийн хэлсэн үг)

Намайг өнөөдөр энд урьсан явдалд Дик Жилеспай болон АНУ-ын Монголын бизнесийн зөвлөлд талархал илэрхийлэв. Ерөнхий сайдыг Вашингтонд хүрэлцэн ирсэнд бид тун баяртай байна. Ерөнхий сайд бол олон жилийн туршуулсныгэмдээ чухал алба хашиж ирсэн хүн юм. Тэрээр 1992 оны 8 дугаар сард Ерөнхий сайдаар томилогдсон цагаас хойш Монголын шинэчлэлийн төгөөгтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Өнөөдөр АНУ-д Ази, Номхон далайн бүс нутгаас илүү чухал бүс нутаг үгүй. Дэлхийн хүн амын ихэнх нь тэр өргөн уудам нутагт оршин амьдардаг. Дэлхий дахины хамгийн баялаг соёлын өвийн олонх нь нь тэнд цэцэглэж байна. Дэлхийн хамгийн эрчимтэй эдийн засаг тэнд харзгдаж даллан, АНУ-ын бизнест өргөн бололцоог бий болгож байна.

Ази нь сөргөлдөөний талбараас дэлхийн түргэн хөгжил бүхий талбай болон хувирч байна. Энэ бүс нутагт эдийн засаг, улс төр, соёлын харилцаа өргөн хөгжиж, улс орнуудын төрх байдлыг өөрчлөн, шинэ бүтэц бий болж, шинэ үеийнхэн удирдлагад дэвшин ажиллаж байна.

Мэдээлэл, чөлөөт зах зээлээр жигүүрлэсэн ардчилалын нийт урсгал Ази болон дэлхий дахиныг хамрах болов. Дэлхий дахины хүн амын ихэнх оршин амьдардаг энэ тивийн нэлээд улс оронд анх удаа ардчилалын ямар нэгэн хэлбэр бүхий засаглал тогтоод байна.

Монгол нь ардчилалд шилжих дэлхий дахины энэ хандлагын нэг тод жишээ болсон юм. Монгол бол Азид коммунизмын дарлалыг таягдан хаясан анхны орон билээ. Ардчилсан хувьсгалаас хойш Монгол нь хэдийгээр хэцүү бэрхшээлтэй тулг арч байгаа боловч өргөн хэмжээний ардчилал, зах зээлийн эдийн засаг бүхий шинэчлэлийг зоригтой хэрэгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд ардчиллын өргөн хандлага дэлхий дахинд ажиглагдаж байгаа бөгөөд Клинтоны засаг захиргаа ардчилсан байгууллыг өндөр үнэлэн дэмждэг юм. Энэ чармайлтыг АНУ идэхтэй дэмжин, эд маториалын болон улс төрийн тусламж үзүүлж байна. Ардчилалд шилжиж буй орнуудад үзүүлэх тусламж нь манай олон улсын тусламжийн хөтөлбөрүүдийн нэг гол хэсэг болов.

Монголд хэрэгжүүлж буй урт хугацааны энэ хөтөлбөр нь ардчилалын хөгжил болон зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бүрэлдүүлэхэд туслан дэмжихэд чиглэж байгаа юм. Бид макро эдийн засгийн зарчмуудаар зөвлөлгөө өгөх, тодорхой тооны хүмүүсийг АНУ-д ирүүлж, өрсөлдөөнт зах зээл, үнийн зохицуулалт, өмчийн эрх, татварын бодлого, маркетингтэй танилцах явдлыг ивээн тэтгэв. Бусад хөтөлбөр нь жижиг аж ахуй, үйлдвэрүүд, орон нутгийн худалдааны танхимууд, үйлдвэрийн эздийн холбоонуудыг байгуулан хөгжүүлэх нөхцлийг бий болгохыг дэмжихэд чиглэж байна. Түүнчлэн бид монголын армийн сургалтанд дэмжлэг үзүүлж байна.

Мөн Азийн фондын хөтөлбөрөөр Монголын засгийн газрын үйл ажиллагааг идэвхжүүлэх явдлыг ивээн тэтгэж байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу Монголын парламентийн гишүүд, шүүх байгууллагад гарын авлага болохуйц зөвлөлгөө өгч байна.

Хөтөлбөрийн дараагийн шат нь бүрэлдсэн тогтолцоог идэвхтэй ажиллагаанд шилжүүлэхэд голлох болно.

Зөвлөлтийн нөлөөний хүрэнээс ангижирсан анхны нэг тусгаар тогтносон улсын хувьд Монгол нь шинэ ардчилсан улсуудад үлгэр дууриал болох алхмуудыг хийж байна. Коммунист ноёрхлын 66 жилийн хугацаанд Монголын нийгэм, эдийн засаг нь ЗХУ-аас ихээхэн хамаарагддаг байсан юм. Монголын эдийн засгийн хөгжил нь эрдсийн нөөцийн үйлдвэрлэлийн хөгжлийг удаашруулан, гол төлөв хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг боловсруулах үйлдвэрийн баазыг анхаарсан төвлөрсөн төлөвлөгөөт загварт нэлэнхүүдээ суурилож байлаа. Монгол нь түүхий эдийнхээ ихээхэн хэсгийг ЗХУ-д нийлүүлэн, оронд нь бэлэн бүтээгдэхүүн авдаг байв. Түүнчлэн нүүдлийн мал аж ахуй нь түүний эдийн засгийн гол салбар хэвээр үлдсэн юм.

1990 оноос ардчилалд шилжих үе эхлэхэд Монгол нь хүн амын боловсролын түвшин өндөр, бараг унаган төрхөөрөө байгаа байгалийн эрдэс баялаг зэрэг олон давуу талтай байв.

Гэвч ЗХУ задран унаж түүний тусламж байхгүй болсон нь 1991 оны эхнээс эхлэн Монголын эдийн засаг хямрал бэрхшээлд орсон юм. Сүүлийн 30 гаруй жилд Зөвлөлтөөс авсан зээл тусламжийн жилийн дундаж хэмжээ

үндэсний нийт бүтээгдэхүүний 30 хувьтай тэнцэж байсны дээр онц шаардлагагүй тоног төхөөрөмж, зөвлөлтийн тусламжаар баригдсан үйлдвэрийн газрууд болон цахилгаан станцуудын сэлбэг хэрэгслийг авахад зарцуулсан хөрөнгө нь улс орныг чөлөөт валютын хомсдолд оруулжээ.

Энэхүү шилжилтийн үед АНУ тэргүүтэй хандивлагч орнууд, олон улсын байгууллагууд Монголд тусламжийн гараа сунгасан билээ. Харин зөвлөлтийн эдийн засаг дампуурч, өр нь ЗХУ-ыг тийм түргэн нурж уначихна гэж хэн ч бодсонгүй. ЗХУ-тай гадаад худалдааныхаа 90 гаруй хувийг хийдэг байсан Монголд ийм том өөрчлөлтийн уршигт нөлөө хамгийн хүндээр туссан юм.

Энэ үйл явдал Монголын эдийн засгийг сүүрлийн ирмэгт авчирав. Монголын тэсгэм өвлийн үед цахилгаан дулааны системийн хуучирч элэгдсэн тоног төхөөрөмжүүд ажиллахгүй болно гэдэг бол улс орны эдийн засгийг сүүрүүлэх аюултай байлаа. Түвшний байнгын хомсдол зөвхөн цахилгаан дулааны нийлүүлэлтэд нөлөөлснөөр барахгүй хаврын тариалалт, ургац хураалтад тусч, эцсийн эцэст хүн амыг хүнсний гачигдалд оруулах аюул тулгарч байлаа.

АНУ-ын тусламжийн хөтөлбөр нь эдгээр хомсдол, гачигдлыг багасгаж, богино хугацаанд зах зээлийн системд шилжих явдлыг дэмжин туслахад чиглэж байна. Өнгөрсөн өвөл Монголын эрчим хүчний салбарт үзүүлсэн манай тусламж нь шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах болон зарим цахилгаан станцын тасралтгүй ажиллагааг хангахад дэмжлэг болсон байх. Тухайлбал өнгөрсөн оны 12 дугаар сард Монголын нүүрсний уурхайд онц шаардлагатай тоног төхөөрөмжийг яг хэрэгцээтэй тэр агшинд АНУ-ын ачааны онгоцоор хүргүүлсэн нь нүүрсний уурхайн ажиллагаа болон түлшээр ажилладаг эрчим хүчний үйлдвэрүүдийн ажиллагааг хангаж өгсөн юм.

Түүнчлэн АНУ Монголд энэрэнгүйн тусламж үзүүлсээр байна. 1991 оноос хойш АНУ-ын БХЯ-ны шугамаар тусгай нислэгүүдийг хийж, эмийн зүйл, эмнэлгийн болон больницын тоног төхөөрөмж, хээрийн эмийн сан, түргэн тусламжийн машинууд нийлүүлэв. Энэ оны (1993) эхээр АНУ 14 сая ам. долларын хүнсний тусламж үзүүлснээс гадна баруун Монголд болсон зудын хөнөөлийг гэтлэн давахад зориулж 25000 ам. долларын тусламж үзүүллээ. Энэ тусламжийн мөнгөөр байгалийн гамшигт нэрвэгдсэн орон нутгийн хүмүүст зориулан хүнсний зүйл, дулаан хувцас худалдааж авсан юм. Гэхдээ, бидний үзүүлж буй тусламж нь Монгол дахь бэрхшээлийн зөвхөн нэг хэсгийг гэтлэн давахад чиглэсэн нь мэдээж.

Өнгөрсөн жил Монголын байдал үнэхээр хүнд болсны жишээ бод өвөл нь Улаанбаатар болон бусад орон нутагт эрчим хүчний салбар түлшээр

дутагдаж сүйрэх аюул нөмөрсөн, хавар нь баруун Монголд ихээхэн цас орж мал олноор үхсэн, зүүн Монголын тал нутаг гал түймэр автагдаж их хохирол үзсэн явдал юм.

Энэ бүх байдла нь ямар ч засгийн газрын тарыг таньж мэдэх шалгуур болсон билээ. Хэдийгээр ихээхэн бэрхшээлтэй байсан ч гэсэн Монгол нь өөрийнхөө шургуу чармайлт, олон члсын хамтын нийгэмлэгийн тусламжтайгаар өнгөрсөн жилийн урт өвлийг гэтлэн лавсан юм. Монголын засгийн газар өндөр үнээр чөлөөт зах зээлийн шинэчлэл, өөрчлөлтийг хийхдээ ОУВС, дэлхийн банктай нягт хамтран ажиллаж байна.

Монгол нь зах зээлийн эдийн засагт шилжих хэсэг болгон үнийг хяналтаас чөлөөлж, өөрийн мөнгөн тэмдэгтийн үнийг бууруулан, чөлөөт валюттай аяндаа зохицуулан сольж байх журам тогтоов. Монгол нь жижиг үйлдвэрийн газруудынхаа 90 шахам хувийг хувьчлаад байна. Өмч хувьчлалын хөтөлбөрийн дараагийн шатанд том үйлдвэрүүдийн ихэнхийг хувийн өмчид шилжүүлэх юм. Банк болон татварын шинэ хуулиуд нь зах зээлийн эдийн засгийг бүрэлдүүлэхэд чиглэж байна.

Шинэчлэлийн эдгээр чухал алхмууд зарим үед богино хугацаагаар олон нийтийн дургүйцлийг хүргэж байгаа боловч Монголын Засгийн газар шинэчлэлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх зориг төгс байна.

Түүнчлэн Монголын ард түмэн ч энэ бодлогыг дэмжиж байгаагаар улт нотлон харуулав. Дөнгөж саяхан хэдхэн хоногийн өмнө ерөнхийлөгчийг нийт ард түмэн анх удаа шууд санал өгч сонгох үеэр Монголын сонгогчдын зонхилох олонхи нь ерөнхийлөгч Очирбатыг дахин сонголоо. Ерөнхийлөгч Очирбат ардчилсан, зах зээлийн чиг баримжаа бүхий шинэчлэлийн бодлогыг идэвхтэй явуулж ирсэн бөгөөд түүнийг ерөнхийлөгчөөр дахин сонгосон явдал бол Монгол улс нь дэлхий дахины шинэ ардчилсан орнуудын дотор ардчилалын нэг тод гэрэл болж байна гэдэг байдлаа дахин нотлон харууллаа.

Очирбат сөрөг хүчнээс нэр дэвшигч байсны хувьд түүний ялалт улам ч ач холбогдолтой юм. Өнгөрсөн жил Монголын залуу, жижиг сөрөг намууд нэгдэн, улам нөлөө бүхий улс төрийн хүчин болж байгаа нь харагдлаа.

Монголын туршлага нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байгаад шинээр тусгаар тогтносон орнуудад бидний зүгээс үзүүлэх тусламжийг хэрэгжүүлэх талаар бидэнд сургамж болох зүйл юм. Учир нь Монгол бол туршлагын хувьд эдгээр орноос хоёр жилээр түрүүлж явна. АНУ-ын эдүүгээгийн зорилт бол ардчилал, хувийн өмчийн (чөлөөт) үйлдвэрлэлтэй танилцахыг хүсч буй улс түмэнд 200 жилийн туршлагаа яаж хүргэх вэ? гэдэг явдал юм.

Америкийн бизнесийн нийгэмлэг энэ үйл явцад чухал үүрэг гүйцэтгэж

чадна. Бизнесийн талаарх ойлголт мэдлэг, түүнийг яаж явуулдаг нь Монголын ирээдүйн амжилтанд чухал зүйл болно. Түүний хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтойг Монголын Засгийн газар ойлгож байгаа ба тэгээд ч гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн тодорхой алхмуудыг хийж байна.

Монголын парламент (Улсын их хурал) саяхан гадаадын хөрөнгө оруулалтын тухай шинэ хууль баталж, түүндээ гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэлээд татсан зүйл оруулав. Түүнчлэн Монгол, АНУ-ын албаны хүмүүс хөрөнгө оруулалтын хоёр талын гэрээ байгуулах талаар нягт хамтран ажиллахын зэрэгцээ уг гэрээнд хөрөнгө оруулалтыг хамгаалах баталгааны заалтууд оруулахаар төлөвлөж байна.

Төгсгөлд нь хэрэв ардчилал, чөлөөт үйлдвэрлэлийг хөгжил цэцэглэлтэд хүрэх үнэнхүү зам гэж монголчууд итгэл төгс хэвээр байгаа бол энэ зүйл бүтэх ч болно, Монгол улс ч амжилтанд хүрнэ гэдэгт би итгэж байна. Ерөнхий сайд Жасрай энэ зарчимд итгэдгээ илэрхийлсэн бөгөөд өнгөрсөн долоо хоногт Монголын ард түмэн ч тэр итгэлийг дэмжиж байгаагаа нотлон харуулав.

Ардчилалд шилжин орох Монголын шинэчлэлд туслаж байгаадаа АНУ бахархаж байдаг бөгөөд ерөнхий сайд, түүний засгийн газартаа нягт хамтран ажиллах болно.